



Нийслэлийн Дотоод аудитын хорооны
даргын Тамгын Газарны 05 сарын 19 өдрийн
01 тоот тогтоолын хавсралт № 1

АУДИТЫН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дотоод аудитын нэгж: **НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА**

Хугацаа: 2014 - 2016

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурал
НАГ	Нийслэлийн аудитын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ЗД	Засаг дарга
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
НД	Налайх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЗАА	Захирагчийн ажлын алба
СА	Санхүүгийн аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЧХ	Чанарын хяналт
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

I. ӨМНӨХ ҮГ

1.1 Танилцуулга

Нийслэлийн дотоод аудитын албаны 2014-2016 оны Дотоод Аудитын Дунд Хугацааны Төлөвлөгөөнд дотоод аудитын үйл ажиллагааны гол зорилго, чиглэл ба хамрах хүрээг тусгасан ба эдгээрийг байгууллагын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн тодорхойлсон.

Аудитын Дунд Хугацааны Төлөвлөгөөг Дотоод Аудитын Дүрэмд нийцүүлэн эрсдэлийн үнэлгээнд суурилан бэлтгэсэн. Аудитын Дунд хугацааны Төлөвлөгөөнд үндэслэн Дотоод Аудитын Жилийн Төлөвлөгөөг бэлтгэсэн ба энэхүү жилийн төлөвлөгөөнд аудитын ажил бүрийн зорилго, хамрах хүрээ, хугацаа, шаардлагатай нөөц зэргийг харуулсан.

Эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг дотоод аудитын олон улсын стандарт болон улсын салбарын дотоод аудитын гарын авлагын дагуу бэлтгэн боловсрууллаа. Дотоод аудитын төлөвлөгөө нь тухайн жилийн эрсдэлд суурилсан дотоод аудитын үйл ажиллагааны хамрах хүрээ, түүнд зарцуулах цаг хугацаа, хүний нөөцийг харуулсан дотоод аудиторын баримтлах гол баримт бичиг болно.

Эрхэм зорилго, стратегийн зорилтууд, бүтэц, зохион байгуулалтын хүрээнд үйл ажиллагааны зорилго, зорилтуудад хүрэхэд сөрөг нөлөө үзүүлж болохуйц нөхцөл, байдлыг судалж, тэдгээрээс хамгийн чухал гэж үзсэн, эрсдэлийн нөлөөлөл өндөр үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр төлөвлөгөөнд тусгалаа.

1.2 Дотоод аудитын нэгжийн үүрэг

Дотоод аудитын нэгж нь Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг Даргын 2014 оны 3 сарын 11-ний өдрийн А/156 дугаар захирамжийн дагуу байгуулагдсан. Дотоод аудитын нэгж нь Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний байгууллагуудын дотоод аудитын хамрах хүрээнд багтсан аудитын объект бүрт аудит хийх үүргийг хүлээнэ.

1.3 Аудитын дунд хугацааны төлөвлөгөөг шинэчлэх

Аудитын дунд хугацааны төлөвлөгөөг жил бүр хянаж, байгууллагын зорилго, үндсэн чиглэл ба үйл ажиллагаанд гарсан өөрчлөлтүүд, эрсдэлийн үнэлгээ зэргийг тусган өөрчлөлт оруулж болно. Аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд хамарсан 2014-2016 оныг дуусвар болсны дараа эрсдэлийн дахин үнэлгээг дэлгэрэнгүй байдлаар хийнэ.

Дотоод аудитын нэгжийн даргын шийдвэрээр аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж болно. Төлөвлөгөөнд хийгдсэн өөрчлөлтүүдийг Дотоод аудитын хороогоор заавал батлуулна.

II. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЙЛГОХ

Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг бэлтгэхийн тулд байгууллагын зорилго, бүтэц ба үйл ажиллагааг судална. Судлах мэдээллийг асуулга авах, уулзалт хийх, ярилцлага хийх, өмнөх аудитын үр дүнд дүн шинжилгээ хийх, мэдээллийн санд хандах зэрэг аргуудаар олж авна.

2.1 Байгууллагын зорилго

Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эрхэм зорилт нь: *“Иргэдийн шууд оролцоонд тулгуурласан нутгийн өөрөө удирдах ёсыг улам бэхжүүлж, төрийн ажлын ил тод, нээлттэй байдлыг ханган, нийслэлээ иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай, байгальд ээлтэй, бие даасан хөгжил бүхий авилгаагүй, агаар цэвэр, найрсаг хот болгон хөгжүүлэхэд оршино”.*

Дээрхи эрхэм зорилгын хүрээнд Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2.2 Байгууллагад гарсан өөрчлөлт

УИХ-ын ээлжит сонгуулийн дараа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэн өөрчлөгдсөн. Энэ өөрчлөлттэй холбоотой статистикийн үзүүлэлтийг 2008 оныхтой харьцуулж үзвэл:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тооны өөрчлөлт

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2008 он	2012 он	Өөрчлөлт /өсөлт/	Өсөлтийн %
ЗД-ын орлогчийн тоо	4	6	2	33,3%
НЗДТГ-ын орон тоо	85	105	20	19,0%
ЗАА-ын орон тоо	40	45	5	11,1%
БЗД, СХД-ийн орон тоо	43	60	17	28,3%
БГД, СБД, ХУД, ЧД-ийн орон тоо	40	55	15	27,3%
БНД, НД-ийн орон тоо	32	35	3	8,6%
БХД-ийн орон тоо	23	25	2	8,0%
Бүгд	267	331	64	19,3%
Агентлагийн тоо	29	32	3	9,4%

Дээрх харьцуулсан хүснэгтээс харахад нийслэлийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тоо нэлээд нэмэгдсэн нь харагдаж байна. Энэ нь дараах үндсэн шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

1. Нийслэлийн хүн ам суурь онтой харьцуулахад 13%-иар өссөн байх бөгөөд нийслэлийн хүн амын улсын дүнд эзлэх хувийг авч үзвэл 39,1% байснаа 45,8%-д хүрсэн.

2. Хүн амын өсөлтийг дагаад нийслэлийн төсвийн орлого 73,5%-иар, зарлага 80%-иар өсчээ. Энэ нь нийслэл дэх бүтээн байгуулалт, эдийн засгийн эргэлт нэмэгдсэнийг харуулж байна.

Нийслэлийн зарим статистик үзүүлэлт

/саяаар/

Үзүүлэлт	2008 он	2012 он	Өөрчлөлт /өсөлт/	Өсөлтийн %
Хүн ам	1 067,4	1 227,0	159,6	13,0%
Улсын дүнд эзлэх %	39,1	45,8	6,7	14,5%
Төсвийн орлого	65 568,0	247 288,3	181 720,3	73,5%
Төсвийн зарлага	53 623,9	267 738,7	214 114,8	80,0%

2.3 Байгууллагын дотоод хяналт

А. Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар нь бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх ажлыг чиглүүлэх үндсэн үүрэг бүхий Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэстэй.

Тус хэлтсийн үндсэн чиг үүрэг нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг үнэлэх замаар нийслэлийн Засаг Даргын бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийг удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Б. Дүүргүүдийн Засаг Даргын дэргэд 2012-2013 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой Дотоод хяналтын албыг байгуулсан байна. Тус алба нь орон нутгийн төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, төсвийн хөрөнгийн үр ашигтай зүй зохистой зарцуулалт, санхүүгийн мэдээллийн үнэн зөв найдвартай байдал, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөл, эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр ашигтай байдалд Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцсэн, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан арга зүйн хүрээнд аудит хийж дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй.

В. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дэргэдэх Үйл ажиллагааны мониторингийн хэлтэс нь харьяа газруудын хэрэгжүүлж байгаа бодлогын шийдвэрийн биелэлт, Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд болон тухайн жилийн нийгэм, эдийн засгийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх зорилготой. Тус хэлтэс нь:

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хамаарах асуудлуудын хүрээний бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга болон холбогдох хэлтэс, байгууллагуудад танилцуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн үүрэг, даалгавар, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийж Ерөнхий менежер болон хэлтэс, харьяа газар, байгууллагуудын удирдлагуудыг мэдээллээр хангах
- Хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн удирдамжийн дагуу хэлтэс, харьяа газар, нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөн холбогдох дүгнэлтийг гарган мэдээлэх
- Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр дүгнэж, үр дүнг Ерөнхий менежерт танилцуулах
- Хэлтэс нь Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, төр засгийн болон нутгийн удирдлагын шийдвэр, үндэсний болон дэд хөтөлбөр, жил бүрийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, үйл ажиллагаан дахь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны чиг үүрэгтэй холбогдсон ажил, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үр дүнг дээшлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилладаг.

Г. НӨҮГ, ОНӨААТҮГ, болон орон нутгийн өмч давамгайлсан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын дотоод аудитор, санхүү нягтлан бодох бүртгэлийн алба, хэлтэсүүд нь дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагад хэрэгждэг дотоод хяналтын талаар судлан үзэхэд эрсдлийн удирдлагын систем болон дотоод хяналтын системийг баримтжуулсан бичгэн бодлого сул байна.

III. ДОТООД АУДИТЫН НЭГЖИЙН ЗОРИЛГО

Байгууллагын 2014-2016 онд хамаарах зорилго, үндсэн чиглэл болон үйл ажиллагаа, дотоод хяналтын талаар олж авсан мэдээлэл дээр үндэслэн дотоод аудитын нэгж дараах аудитын эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон.

Нийслэлийн дотоод аудитын албаны эрхэм зорилго:

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулахад оршино.

Дээрхи эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлсон. Үүнд:

1. Аудитын дунд хугацаанд аудитын хамрах хүрээний бүх объектуудад эрсдэлд суурилсан дотоод аудитыг хийн, дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн байх;
2. Судалгаа шинжилгээ хийн, сургалт явуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын засаглал, эрсдлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор арга зүйн зөвлөмжөөр хангах;
3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийг үнэн зөв мэдээллээр ханган, удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах;

Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөний хамрах хугацаанд дотоод аудитын нэгжийн хийж гүйцэтгэх аудитын ажлууд болон үйл ажиллагааг Дотоод аудитын жилийн төлөвлөгөөнд харуулсан.

IV. АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хамрах хүрээг тодорхойлохдоо Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагууд, Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтуудыг авч үзсэн.

2013 онд нийслэлийн хэмжээнд тус бүр 9 дүүрэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн иргэдийн хурал, Захирагчийн ажлын алба, Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжин үйл ажиллагаа явуулдаг 15 хэлтэс, Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг 32, төсөвт 35, 47 төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллага нийт 138 байгууллага, нэгжийн мэдээлийн санд нэгтгэсэн.

Дунд хугацаанд хийх аудитын хамрах хүрээ

№	Аудитын объектууд	Тоо
1	Дүүргүүд	9
2	Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлаг	32
3	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар	47
4	НЗД бөгөөд УБ хотын захирагчийн харъяа төсөвт байгууллагууд	35
5	НЗД-ын дэргэдэх хэлтсүүд	15
Нийт		138

V. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

5.1 Тодорхойлсон эрсдэлүүд

Дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулах үндсэн суурь үзүүлэлт нь эрсдэлийг тодорхойлж, түүнд үнэлгээ хийх явдал билээ. Олон улсын жишиг хандлагаар тухайн байгууллагын нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааны эрсдэлийг анхлан тодорхойлж, хэрэв эрсдэлийг удирдах алба нэгжтэй бол тус нэгж нь тодорхойлсон эрсдэлийн жагсаалтыг хянан үзэж, өндөр эрсдэлтэй нөлөө бүхий үйл ажиллагааг сонгон аудитын төлөвлөгөөнд ихэвчлэн тусгадаг. Бид аудит хийгдэх объектийн эрсдэлийн үнэлгээг хийсэн. Энэхүү тогтоосон эрсдэлийн түвшин дараа, дараагийн жилүүдэд улам боловсронгуй болж, улмаар эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө сайжрах нөхцөл бүрдэнэ.

Аудитын объектуудын эрсдлийн судалгааг хийхдээ дараах үзүүлэлтүүдийг ашигласан. Үүнд:

- ✓ Байгууллагын үр дүнгийн болон контракт гэрээний үзүүлэлт:
НЗД-н 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/282 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын захирлуудын контракт гэрээний дүгнэсэн дүн, НЗД-н 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/44 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, УБ хотын захирагчийн харьяа газрууд болон Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд, нийслэлийн төсөвт байгууллагуудын 2013 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн
- ✓ Төсвийн санхүүжилт ба борлуулалтын орлогын үзүүлэлт:
Нийслэлийн төрийн сангийн мэргэжилтэний гаргасан төсөвт болон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн нэгтгэл, төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээлэл
- ✓ Хөндлөнгийн аудитын дүгнэлт үзүүлэлт:
Нийслэлийн аудитын газрын цахим сайтын мэдээлэл, НМХГ-ын шалгалтын дүн, 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
- ✓ Тогтвортой байдлын үзүүлэлт:
Байгууллагуудын тогтвортой байдлын үзүүлэлтийг тооцохдоо тухайн байгууллагын удирдлагын түвшинд орсон өөрчлөлтийг харгалзан үзлээ. Мөн мэдээлэл, эх сурвалжийг бусад нөлөөлөл гэж хамааруулан үзсэн болно. Тухайлбал тус байгууллага нь 2012 оноос хойш шинээр зохион байгуулагдсан бол 5 оноо, байгууллагын бүтэц, удирдлага өөрчлөгдсөн бол 4 оноо, байгууллагын ерөнхий нягтлан бодогч эсвэл санхүүгийн албаны дарга өөрчлөгдсөн бол 3 оноо, байгууллагын нэгжийн удирдлага буюу хэлтсийн дарга нарын 50-иас дээш хувь нь өөрчлөгдсөн бол 2 оноо, бүтэц, удирдлага өөрчлөгдөөгүй бол 1 оноо өгч үнэллээ. Дээрх үнэлгээг гаргахдаа тухайн байгууллагын холбогдох албаны хүмүүстэй утсаар холбогдон шаардлагатай мэдээллийг цуглуулсан болно.

- ✓ Аудитын зөвлөмжийн хэрэгжилт үзүүлэлтийн хувьд бид аудит хийж эхлээгүй байгаа тул бүх байгууллагыг маш бага гэсэн эрсдлийн шалгуураар тус тус үнэлсэн болно.

5.2 Эрсдэлийг хэмжиж үнэлэх, эрсдэлийг ач холбогдлоор нь зэрэглэх

Эрсдэлийг хэмжихэд ашигласан тохиолдох магадлал ба нөлөөллийн тоон ба чанарын түвшинг дараах байдлаар тооцооллоо.

Эрсдлийн нөлөөллийн хэмжилтийг 5 шалгуур үзүүлэлтийн хувьд тооцсон нь:

№	Тоон түвшин	5	4	3	2	1
	Чанарын түвшин Эрсдлийн шалгуур үзүүлэлтүүд	Маш их	Их	Дунд	Бага	Маш бага
1	Төсвийн санхүүжилт /Борлуулалтын орлого/-ын хэмжээ	10 тэрбум төгрөгөөс дээш	5-10 тэрбум төгрөг	1-4 тэрбум төгрөг	0.5-1 тэрбум	0.5 тэрбум төгрөгөөс доош
2	Үр дүнгийн гэрээ болон контракт гэрээний үнэлгээ	Бүрэн хангалтгүй	Хангалтгүй	Хангалттай боловч, ажил сайжруулах	Хангалттай	Бүрэн хангалттай
3	Аудитын байгууллагын үнэлгээ, дүгнэлт	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Сөрөг дүгнэлт	Хязгаарлалттай дүгнэлт	Зөрчилгүй дүгнэлт	Дүгнэлтгүй
4	Тогтвортой байдал	Шинээр зохион байгуулагдсан	Байгууллагын бүтэц, удирдлага өөрчлөгдсөн	Нягтлан бодогч эсвэл санхүүгийн албаны дарга өөрчлөгдсөн	Байгууллагын нэгжийн удирдлага өөрчлөгдсөн	Өөрчлөлтгүй
5	Зөвлөмжийн хэрэгжилт	-	-	-	-	Маш сайн мөрддөг

5.3 Эрсдэлийн үнэлгээний үр дүн

Тухайн эрсдлийн шалгуур үзүүлэлтүүдийн хувьд харгалзах тоон түвшний оноог өгөх бөгөөд оноонуудыг хооронд нь үржүүлж нийлбэрийг нь гарган гаргасан нийт оноогоор аль Чанарын түвшинд байгаагаар нийт эрсдлийг тодорхойлно.

Эрсдлийн үнэлгээний хүснэгт

Эрсдлийн үнэлгээ	Эрсдлийн түвшин	Цаашид авах арга хэмжээ
Их	20-иос дээш	Ойрхон хугацаанд шалгаж байх
Дунд	10-19	Тогтмол шалгаж байх
Бага	1-9	Зарим тохиолдолд шалгаж байх

VI. АУДИТЫН АРГАЧЛАЛ

6.1 Давтамж

Их, Дунд, Бага эрсдэлтэй гэж үнэлсэн аудит хийгдэх объектуудад дотоод аудит хийх давтамжийг дараах байдлаар харуулсан.

Эрсдэл	Жил	Давтамж
Их эрсдэлтэй	1 жил	1 удаа
Дунд эрсдэлтэй	2 жил	1 удаа
Бага эрсдэлтэй	3 жил	1 удаа

Эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тухайлсан аудитын ажилд зарцуулах хүн-өдрийг тодорхойлсон. Аудитын ажилд зарцуулах хугацааг гаргахдаа тухайн хуанлийн жилийн ажлын өдөр, ажиллах аудитор шинжээч нарын тоог харгалзан үзсэн.

Зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр эргэн хянах- Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн мөрөөр эргэн хянах горимыг хэрэгжүүлэхэд 22 хүн-өдөр зарцуулна.

6.2. Аудитын ажилтны ажил үүргийн хуваарилалт

Дотоод аудитын нэгжийн ажилтан бүрт ажил үүргийг дараах байдлаар хуваарилна.

- Нийт хүн-өдрийн 80% – Дотоод аудитын баталгаажуулах ажил, дунд хугацааны ба жилийн төлөвлөлтийн ажилд зарцуулах;
- Нийт хүн-өдрийн 15% – Дотоод аудитын нэгжийн удирдлагын үйл ажиллагаанд зарцуулах;
- Нийт хүн-өдрийн 5% – Сургалт, семинар гэх мэт бусад төрлийн үйл ажиллагаанд зарцуулах.